

ДОРНЫН УЯНГАТ ЭРДЭНЭ – КЬОҮ БҮСГҮЙН ТУУЖ*Г.Мэнд-Ооёо**

Монголын оюунт мэргэн уншигч олны ном эрдэнэсийн сан хөмрөгт нэгэн гайхалтай бүтээл нэмэгдэж байгаа нь Вьетнамын сонгодог утга зохиолын оргил болсон “Кьюү бүсгүйн тууж оршвой” хэмээх зүрх сэтгэлийг уяруулан эзэмдэгч энэхүү уянга яруу туурвил болой.

Кьюү бүсгүйн тууж бол Вьетнамын ард түмнээс хүн төрөхтөний яруу найргийн сан хөмрөгт оруулсан уянга эгшиглэнт эрдэнэ мөн. Хүмүүний гоо үзэсгэлэн, тэр тусмаа бүсгүй хүний дотоод ертөнцийн яруу сайхныг нэн гайхалтай нээж, хэдийгээр бурангуй тавилангийн золиос болсон ч дотоод мөн чанараа мөнхөд нандигнан хадгалж үлдсэн Кьюү бүсгүйн хувь заяа, хайр сэтгэлийн түүх нь хүн гэгч ямар агуу гайхалтай оюун сэтгэлийн цэвэр тунгалагийг хадгалагч байж чадахын үлгэрт туульс ажээ. Кьюү бүсгүйн туужийг уншсан хэн боловч байгаль хийгээд хүмүүний зохист яруу сайхан, дорнын үзэмж төгс ахуй, үг хэлээр илэрхийлэн найруулах яруу найрагчийн туурвилын уран чадварыг гайхан таашаах нь мэдээж.

Дундад зууны нэгэн бичгийн мэргэн Вьетнамын сонгодог зохиолч Нгүен Зү уламжлалт бичгийн хэл найруулга хийгээд тухайн цаг үеийн ярианы хэлийг чадамгай хослуулж, яруу найргийн бадаглалт чанд тиг дотор үйл явдал, утга уянга, уран үгүүлэхүйн эрдмийг төгс найруулан туурвисан энэхүү бүтээлээрээ дэлхийн нэрт хүмүүсийн жагсаалтад зүй ёсоор орсныг Юнескогоос зарлан тунхагласан болой.

Туужид эртний дорно дахины хайр сэтгэлийн уран домог хийгээд Хүннү гүрний хаанд олзлогдсон Хан үндэстний гүнж, яруу найрагч Цяо Гуаны холхи нутгаа санагалзан дуулсан гунигт дуулал, эртний нанхиадын Ачлалт ном, Тан Улсын уран зохиол дахь хайр сэтгэлийн адал явдал зэргийг гэрч татан дуулсан байдаг нь туурвил сэтгэлгээний баялаг цар хүрээг илэрхийлнэ.

Бүсгүй хүний гоо сайхныг дүрслэхдээ:

Мэлмий нь намрын ус мэт тунгалаг

Хөмсөг нь хаврын уулс мэт хөхөмдөг

гэх буюу хөгжмийн яруу эгшгийг дуулахдаа:

Чавхдасын дуу нэгэн үе галбинга шувуу

Нисэн өнгөрөх лугаа тунгалаг болж

Бас усны хүрхрээ нургих мэт бүдгэрнэ.

Заримдаа далайн цээлд салхин үлээх мэт уужирч

Заримдаа тэнгэрийн хур асгарах мэт шагширна

хэмээжээ. Юутай яруу тунгалаг дуулна вэ? Кьюү бүсгүйн тууж энэ мэт яруу найргийн эрхэмсэг уран дүр дүрслэл, элгэмсэг уяхан эгшиг

* Г.Мэнд-Ооёо - яруу найрагч, утга зохиолын судлаач

аялгуугаар нэн баялаг байгаагийн дээр нийтлэг агуулгын сургамжит санаа нь зуун зууны залуу хүмүүст хайр сэтгэлийн эрхэм дээдийн утга чанарыг нэн сэтгэл уярмаар, өрөвдөн хайрламаар бичиж илгээсэнд байгаа юм. Тэгээд ч

“Харж үзээгүй хэмээн тэнгэр бурханыг бүү зэмлэ
Сайн явахын язгуур нь сайхан сэтгэлийн үзүүрт оршино”

хэмээх зохиолчийн нэгэн үзүүрт санаа зохиолын төгсгөлд нэн тодорхойёо болж байна. Энэ нь манай Монголын ард түмний “сайн явах санааных” хэмээх мэргэн үгтэй утга дүйж байна. Ерөөс дорно дахины уран зохиолын нэн эрхэмсэг уян налархай, уярам зөөлөн өнгө аялгуу, шувуу жигүүртэний цээл жиргээ анхилуун цэцэгсийн үнэр, бийбаа тэргүүт чавхдаст хөгжмийн цангинаат эгшиг энэ туужийн эхнээс төгсгөлийг хүртэл нэвт уянгалах болой.

Миний бие “Кьюү бүсгүйн тууж оршивой” хэмээх энэхүү алдарт сайхан туурвилыг өөрийн монгол хэлээрээ шимтэн уншсан анхны уншигч нь болсон азтай хувь тохиосондоо баясахын сацуу Вьетнам эх хэлнээс нь нэн уян налархай найрсуулж, утга зохилдуулан чадамгай орчуулсан нэрт орчуулагч, эрдэмтэн судлаач С.Дашцэвэлд талархлын дээд хүндэтгэлээ илэрхийлсү.

Вьетнамын Их сургуульд суралцаж, Вьетнам түүх соёлын, зан заншил, ахуй амьдралыг сайн мэдэх болсон эрдэмтэн тэрбээр сурч эзэмшсэн нь орчуулгаас тов тодорхой мэдэгдэж байна. С.Дашцэвэл бээр Олон улс судлал, Ази Дорно дахин судлалын эрдэмтний хувьд олон ном бүтээл туурвисны зэрэгцээ Вьетнам хэлнээс олон сайхан зохиол орчуулж монгол уншигч нартаа толилуулжээ. Хо Ши Миний “Шоронд бичсэн тэмдэглэл”, “Вьетнам ардын үлгэр, домог”, “Вьетнам өгүүллэгийн түүвэр” зэрэг олон ном орчуулж, Вьетнамын яруу найрагч Занг Нам, Хюй Кан, Те Хань, Суан Зьюү, Ле Ань Суань, Лү Фьонг Льен, Суань Күйнь, Лыонг Ан зэрэг яруу найргаас монгол уншигч нартаа толилуулсан нь хоёр орны соёл, утга зохиолын харилцаанд чухал хувь нэмэр болсон нь дамжиггүй.

Орчуулагч С.Дашцэвэл “Кьюү бүсгүйн тууж оршивой” хэмээх эл туурвилыг орчуулахдаа олон жилийн турш бодож тунгааж, судалгааны ном бүтээл үзэж, франц, англи, орос, нанхиад орчуулгуудыг нь харьцуулан судалж, уг зохиолын үгийн тайлбар толь зэргийг орчуулгандаа ашиглаж баярлалтай сайхан үйлс бүтээжээ.

Аливаа ард түмний билиг оюуны сан хөмрөгөөс орчуулна гэдэг бол өөрийн улс үндэстний эрдэм номын хүү санг арвижуулах үйлс мөн. Ард түмнүүдийн зүрх сэтгэлийг улам ойртуулан ойлголцуулах утгаараа энхийн дипломат үйлс мөн. С.Дашцэвэл орчуулагчийн эл бүтээл монголын орчуулга – эрдэнэсийн санд орох дорвитой туурвил болсныг анхны уншигч нь болсны хувьд амжаад хэлчихье. Тэр тусмаа дорно

дахины их утга зохиолоос Вьетнамын уран зохиолын орчуулгыг энэ хүн ганцаараа үүрч явна.

Вьетнамын сонгодог уран зохиолын дээж болох Кьюү бүсгүйн тууж монголын мэргэн уншигчид хийгээд уран зохиолын хорхойтнуудын таашаалд нийцэж оюун сэтгэлийг ариусган тунгалагшуулахад үлэмж хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Номын цагаан буян арвижих болтугай.